

ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА (Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь)

COOPERATION BETWEEN LAW ENFORCEMENT ORGANIZATION (Developing cooperation for Monitoring Evaluation, Internal Audit)



М.БАТСАЙХАН

Хууль зүйн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

BATSAIKHAN M.

Officer of the Department for Monitoring, Evaluation and Internal audit

Товч утга: Хууль сахиулах байгууллагуудад хамтын ажиллагаа зохих түвшинд хэрэгжиж байгаа бөгөөд байгууллагын удирдлагыг мэдээллээр хангаж, зорилго, зорилт хангагдаж байгаа, үйл ажиллагаа хэвийн явж буйд үнэлгээ хийдэг нэгж, албан тушаалтнуудыг мэргэшүүлэх, уг нэгжийг чадавхжуулахад чиглэсэн хамтын ажиллагаа хангалтгүй байна.

Энэ талаар Хууль зүйн яамтай хамтран Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж буй төслөөс өөр арга хэмжээ хэрэгждэггүй гэж үзэж болохоор байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг байгууллагын удирдлагын түвшинд сайн ойлгож, дэмжих, нэгжийг чадавхжуулснаар сайн төлөвлөлт, зөв гүйцэтгэл, үр дүн, үр дагавар, үр нөлөөг бий болгох, зайлшгүй залруулгыг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлсэнээр эрх зүйн шинэтгэлийг хөгжүүлэх, бодлого, байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах, нөөцийг хэмнэх, үргүй зардлыг бууруулах сайн талтай.

Иймд хууль сахиулах байгууллагуудын гадаад болон дотоод хамтын ажиллагаанд энэ талаар тусгаж, хэрэгжүүлэх нь зайлшгүй шаардлагатай байгааг тусгаж өгсөн.

Мөн хамтын ажиллагааг хөгжүүлэн, бэхжүүлэхэд анхаарах хэд хэдэн санаа, жишээг дэвшүүлсэн болно.

Abstract: International cooperation among law enforcement agencies is fairly developed but capacity building and cooperation aiming at empowering unit and its officers in monitoring and evaluating achievement of organization's goals and objectives and quality of provisions of information available for management team are insufficient.

At the moment, Ministry of Justice is implementing a project in collaboration with GIZ (German International Cooperation) in regards of developing international cooperation.

It is believed that in order to promote ongoing legal reform, development of policies and ensure normal operation of the organization, increase resources and cost effectiveness, we have to support and understand the importance of strengthening capacity in monitoring and evaluation at organizational level and create a condition necessary for good planning, proper implementation, reaching for good result and consequences and make a room for timely correction.

Therefore, it is essential that taking into account of the needs for capacity building in monitoring and evaluation when developing national and international cooperation.

Lastly, I included some of my ideas and examples that you may pay attention to in developing cooperation.

Агуулга:

1. Хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааны тухай;
2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тухай товч ойлголт, өнөөгийн байдал;
3. Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаанд хяналт-шинжилгээг хөгжүүлэх нь.

Нэг. Хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа нь гадаад, дотоод гэсэн ангилалаар зохион байгуулагдаж байгаа бөгөөд хэрэгжиж буй хэлбэрээр нь 2 талт, гурвалсан, олон талт гэх зэргээр авч үздэг байна.

Монгол Улсын гадаад харилцаа хөгжихийн хирээр гадаад орнуудад зорчих, ажиллаж амьдрах, аж ахуй, бизнес эрхлэгч иргэдийн тоо өсөн нэмэгдэж байгаа тул тэдгээр иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх хэрэгцээ шаардлага бий болсоор байна.

Эдгээр хэрэгцээ шаардлагын хүрээнд Хууль сахиулах байгууллагын гадаад хамтын ажиллагааг Засгийн газар, яам, агентлагын түвшинд гэрээ хэлэлцээр байгуулах замаар харилцан ашигтай байдлаар гадаад хамтын ажиллагааг хөгжүүлсээр ирсэн.

Хууль зүйн сайдын 2014 оны А/231 дүгээр тушаалаар баталсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний гадаад харилцааг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн зорилго, ач холбогдол нь Төрийн гадаад бодлогын нэгдсэн байдлыг хангах зарчмын хүрээнд эрх зүйн 2 болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, гэрээ, конвенцид нэгдэн орох, гэрээ хэлэлцээрийг шинээр байгуулах, цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх, яам болон харьяа агентлаг, байгууллагыг чадавхжуулах, шинэ арга барил, техник технологийг нэвтрүүлэх, тэдгээрийн албан хаагчдын мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байдаг.

Хууль сахиулах байгууллагууд нь 2014 оны жилийн эцэсийн байдлаар гадаад 11 орны 40-өөд байгууллагатай гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлсэн тоо баримт байна.

Дотоод хамтын ажиллагааг хууль сахиулах байгууллагууд харьцангуй хязгаарлагдмал түвшинд буюу байгууллагын чиг үүргийн онцлогт нийцүүлж хамтран ажиллах санамж бичиг байгуулах, эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хэрэг зөрчил шалгах, гамшгийн үед дэмжлэг үзүүлэх зэрэг нэгдсэн арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулж байна.

Өөрөөр хэлбэл, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа сайн хөгжөөгүй байна гэсэн дүгнэлт гарч ирж байна.

Хоёр. Аливаа байгууллага, хамт олон үйл ажиллагааныхаа үр дүнг хэмжих (үнэлэх)-гүй бол амжилтыг алдаанаасаа ялгаж чадахгүй болдог. Амжилтаа хараагүй бол түүнийг урамшуулж чадахгүй, улмаар алдаагаа засах биш харин ч эсрэгээр нь урамшуулж байдаг байна. Иймд энэхүү өгүүлээр дэвшүүлэх гол санаа бол хяналт-шинжилгээ, үнэлгээний хамтын ажиллагааг хууль сахиулах байгууллагуудад хөгжүүлэх асуудал юм.

Аливаа байгууллагад хүний нөөцийн, санхүүгийн болон хариуцлагын гэсэн 3 хөлт тулгуур тогтолцоо зайлшгүй хэрэгтэй байдаг шиг Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь байгууллагын удирдлагын салшгүй нэг тогтолцоо байх ёстой.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо нь байгууллагын удирдлагын

өвөрмөц арга хэрэгсэл бөгөөд үр дагаврыг хэмжих (үнэлэх)-д үүнийг хэрэглэж улмаар удирдах болон шийдвэр гаргах үйл ажиллагааг мэдээллээр хангах нэн чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хяналт-шинжилгээ гэдэг нь мэдээллийг системтэйгээр цуглуулж, хэрэгжүүлж буй арга хэмжээний дүнд гарах ахиц өөрчлөлт, зорилтын хэрэгжилтийг задлан шинжилж, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагаа юм.

Энгийн утгаараа бол үйл ажиллагааны хэрэгжилт (орц, явц, гарц), үр дүн (үр нөлөө, үр дагавар)-г судлах, хэмжих, дүгнэх, мэдээлэх ажиллагаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний

Зорилго	Үйл ажиллагааны ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ-ийг сайжруулах
Үүрэг	- Удирдлагын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
	- Үйл ажиллагааны хэрэгжүүлэлтийн үеийн дэвшлийн замыг зураглах
	- Оролцогч талуудын мэдлэг, оролцоог дэмжих
	- ҮР ДҮН-г зарцуулсан НӨӨЦ-тэй харьцуулах
	- ҮНЭЛГЭЭ-г суурь өгөгдлөөр хангах

Үнэлгээ гэдэг нь үйл ажиллагааны үр дүнг системтэй, бодитой үнэлж дүгнэх нэг удаагийн ажиллагаа юм.

Өөрөөр хэлбэл зорилго, үйл ажиллагааны уялдаа, хэрэгжилт, үр дүн, үр нөлөөг тодорхойлох ажиллагаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний харьцуулалт

Хяналт-шинжилгээ	Үнэлгээ
Тасралтгүй үргэлжилж байдаг	Үе шаттай хийгддэг, цаг хугацааны хязгаартай
Дотоод үйл ажиллагаа	Өөрийн, хөндлөнгийн, хамтарсан үйл ажиллагаа
Удирдлагын чиг үүрэг	Ажилтнууд, үнэлгээчид, удирдлагын хамтын
Мэдээллийн эргэх холбоо тогтмол хийгддэг	Мэдээллийн эргэх холбоо тодорхой хугацаанд хийгддэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах субъектүүд холбогдох эрх зүйн зүйн актуудын хүрээнд хэрэгжүүлнэ.

Тогтолцоо	Субъектүүд	Эрх зүйн актууд
Засгийн газрын хуралдаан	Засгийн газар	Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”
Засгийн газрын хэрэг эрхлэх газар	Яамд	

Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагууд	Агентлаг (Аймаг, нийслэлийн засаг дарга)	-Сайдын 2014 оны А/01 дүгээр тушаалаар баталсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”
	Улсын төсөвт айгууллагууд (Засаг даргын тамгын газар)	
	Төрийн өмчит хуулийн этгээд	-Агентлагын даргын баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”

Хяналт-шинжилгээ, үнэлгээг үр дүнд суурилж явуулах нь илүү ач холбогдолтой байдаг. Өөрөөр хэлбэл байгууллагын аливаа үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт нь дэвшүүлсэн зорилго, зорилтот түвшингийн хэмжээнд явагдаж байгаа эсэхэд үнэлэлт өгч, шаардлагатай залруулгыг тухай бүр нь авч хэрэгжүүлснээр зорилго, зорилт бүрэн хангагдана гэсэн үг юм.

Энэ нь байгууллагын удирдлага үйл ажиллагаагаа төлөвлөх (орц)-өөс эхлээд хэрэгжүүлэх, хэрэгжиж дуусах (гарц) болон гарах үр дүнг агуулсан бүх мэдээллийг илүү сайн мэдэхэд дэмжлэг үзүүлэх дүн шинжилгээний тогтмол хэлбэр юм.

Байгууллагын удирдлагад үйл ажиллагааны үр дүн, үр дагаврын талаарх мэдээлэл өгөх ажиллагаа дутмаг хийгдэж байгаагаас үүдэн салбар, нэгжийн чиг үүргийг давхардал, ажлын хийдэл, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд тавих хяналт алдагдах гэх зэрэг сөрөг үр дагавар тодорхой хэмжээгээр гарч байна.

Иймд хяналт-шинжилгээ, үнэлгээ нь байгууллагын удирдлагын салшгүй нэг тогтолцоо байх шаардлага бий болоод байна.

Гурав. Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах чиглэлээр нэвтрүүлж, хамтран ажиллах нь илүү үр дүнтэй гэж үзээд Та бүхэнд саналаа танилцуулж байна. Үүнд:

1. Байгууллагууд хоорондоо хяналт-шинжилгээ, үнэлгээний хамтын ажиллагааг бэхжүүлж, харилцан туршлага солилцох. Учир нь Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд үг, хэллэг, үнэлгээний хувьд нэг ижил ойлголттой байх шаардлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, 2-3 газар нэгэн зэрэг хэд хэдэн албан хаагч ижил үйл ажиллагаанд үнэлгээ хийхэд тэдний үнэлгээ ойлголтын зөрүүнээс болж өөр өөрөөр гарахгүй, харин бодитой үнэлгээ өгөх нөхцөл бүрдэнэ гэсэн үг.

Жишээ нь: Засгийн газрын 322 дугаар тогтоолын дагуу жилд нэг удаа байгууллагын үйл ажиллагааны үнэлгээг шат, шатандаа гүйцэтгэдэг. Энэ үед ойлголт муу нэг нь тааруухан гүйцэтгэлтэй ажлыг сайнаар үнэлээд, журмаа мэддэг нь сайн гүйцэтгэлтэй ажлыг зохих хэмжээнд нь үнэлсэнээс болж байгууллага, хамт олныг зүтгэл, хөдөлмөр үнэ цэнэгүй болохтой адил юм.

2. Ижил чиг үүргийг хэрэгжүүлдэг эсвэл нэг чиг үүргийг хамтран хэрэгжүүлдэг байгууллагууд тухайн чиг үүрэгтээ хамтран үнэлгээ хийх, тулгамдсан асуудлыг хамтран тодорхойлох нь хамтын ажиллагааны бас нэгэн хэлбэр байх хэрэгтэй гэж үзэж байна.

Жишээ нь: Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл шалган нэвтрүүлэхэд хил хамгаалах байгууллага, хилийн мэргэжлийн хяналт, гааль, Иргэний харьяалал, шилжилт, хөдөлгөөний ерөнхий газар гээд томоохон байгууллагууд оролцдог. Гэтэл улсын хилээр цогцос, хориглосон бараа гарсаар л байна. Газар дээр нь

очоод судлахаар чиг үүрэг буюу хэн, юуг хэзээ үзэж, шалгах нь тодорхойгүйгээс манай биш, тэднийх үзнэ гэдэг байдлаар албанд хандаж үзлэгийг орхигдуулж байна.

3. Гадаад орнуудын хууль сахиулах байгууллагуудтай хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр хамтын ажиллагаа байгуулахдаа хууль сахиулах байгууллагууд бүгд оролцож, ижил түвшинд хөгжих.

Хууль зүйн яам 2006 оноос эхлэн Германы хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-тэй хамран хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр хамтран ажиллаж 20 гаруй удаагийн сургалт зохион байгуулж, хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг хамруулж, чадавхжуулсан.

4. Байгууллага нэгжийн болон албан хаагчдын ажил дүгнэх болон дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулахдаа Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын хавсралтын 62, 63 дугаар зүйлд заасан үнэлгээний хэлбэрийг ашиглах.

Энэ нь ажлын явцыг тодорхой болгох, бодитой үнэлэх ач холбогдолтой.

Төгсгөл.

Байгууллагын зорилго юу вэ?, Зорилгодоо хүрч чадаж байна уу?, Хүрсэн эсэхийг хэрхэн нотлох вэ? гэсэн асуултанд хариулт өгөх, энэ тогтолцоог хөгжүүлэх, боловсронгуй болгоход байгууллагын хамтын ажиллагааг чиглүүлэх шаардлага байгааг эрдэмтэн, судлаачид Та бүхэн анхааралдаа авч ажиллахыг хүсье.

Нэг минутын менежерийн “Төлөвлөлт, сайшаал, зэмлэл” гэсэн ажлын арга барил нь хяналт-шинжилгээ, үнэлгээний хамгийн хялбар, үр дүнтэй арга гэж би хувьдаа ойлгосон. Та бүхнийг мөн судалж үзэхийг хүсье.

Сайн менежер (удирдагч)-ийн ажлын амжилт, байгууллагын тогтвортой үйл ажиллагааны үндэс нь ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ.